



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2022 оны 02 сарын 22 өдөр

Дугаар 04

Мандалговь

Р.Мөнхбатыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын  
хөгжлийн газрын Захиргаа, хүний нөөц хариуцсан  
ахлах мэргэжилтний албан тушаалд  
нэр дэвшүүлэх тухай


Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2021 оны 7 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Захиргаа, хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Равдандоржийн Мөнхбат 59.3 оноогоор тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлсүгэй.

Хоёр Ажлын байрны шаардлагыг хангаж байгаа Р.Мөнхбатын холбогдох материалыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг салбар зөвлөлийн ажлын албанд даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ТӨРБАТ





**Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Захиргаа,  
хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалд  
нэр дэвшүүлсэн Р.Мөнхбатын тухай дүгнэлт**

1. Р.Мөнхбат нь 1991 онд Дундговь аймгийн Дэлгэрцогт суманд төрсөн. 31 настай, эрэгтэй
2. Боловсролын байдал: 2009-2013 онд Хууль сахиулахын их сургуулийг Эрх зүйч мэргэжлээр бакалаврын зэрэгтэй суралцаж төгссөн.
3. Туршлага: 2013-2019 онд Дундговь аймгийн Цагдаагийн газарт хэсгийн мөрдөгч, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газарт захиргаа, хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтний албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байсан.
4. Р.Мөнхбатын төрийн албанд ажилласан туршлага, тухайн ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа болон тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн зэргийг харгалзан Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын захиргаа, хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалд томилуулах санал, дүгнэлтийг гаргаж байна.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ